



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/139


Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр
албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллахыг дэд захирлууд, албадын дарга, клиникийн эрхлэгч, ахлах сувилагч, нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
2. 01 дүгээр албан даалгаврыг төвийн цахим хуудас, фэйсбүүк групп, мэдээллийн самбаруудад байрлуулан нийтэд ил тод мэдээлэхийг Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /С.Ариунболд/-д үүрэг болгосугай.
3. 01 дүгээр албан даалгавар болон Эрүүл мэндийн яамны удирдлагуудаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө гарган, батлуулахыг Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн /С.Ариунболд/-д, хэрэгжүүлэн ажиллахыг дэд захирлууд, албадын дарга нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

001148